



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 1215

Улаанбаатар хот

Хуваарь батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.1, 24 дүгээр зүйлийн 24.3.3, 25 дугаар зүйлийн 25.5, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, Тусгай зориулалтаар 2023 онд агнах барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай Засгийн газрын 2022 оны 444 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тусгай зориулалтаар 2023 онд агнах, барих амьтны тоо хэмжээ, зүйлийг хавсралт ёсоор баталсугай.

2.Тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах, барих зөвшөөрлийн дуудлага худалдааг тухайн жилд агнах, барих амьтны тоо, толгойн дээд хязгаараас хэтрүүлэхгүйгээр, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, хэрэгжилтийн мэдээллийг 2023 оны 08 дугаар сарын 01-ний дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн удирдлага, зохицуулалт, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллахыг Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газар (Ц.Уранчимэг)-т үүрэг болгосугай.

САЙД



Б.БАТ-ЭРДЭНЭ

152310668

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн
А/215 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



АЙМГУУДАД ТУСГАЙ ЗОРИУЛАЛТААР АГНАХ АМЬТНЫ ТОО ХЭМЖЭЭ ХУВААРЬ

| № | Аймгуудын нэрс | Угалз | Тэх | Халиун буга | Цагаан зээр | Бор гөрөөс | Зэгсний Зэрлэг гахай | Саарал чоно | Агнуурын шувуу |
|----|----------------|-------|-----|-------------|-------------|------------|----------------------|-------------|----------------|
| 1 | Архангай | 2 | 2 | 2 | | | | | |
| 2 | Баянхонгор | 8 | 27 | | | | | | |
| 3 | Баян-Өлгий | 15 | 28 | 5 | | | 8 | | |
| 4 | Булган | | | 4 | | | | | |
| 5 | Говь-Алтай | 3 | 21 | | | | | | |
| 6 | Говьсүмбэр | 1 | | | 25 | | | | |
| 7 | Дорноговь | 7 | | | | | | | |
| 8 | Дорнод | | | 2 | 40 | 2 | | | |
| 9 | Завхан | 2 | 4 | 6 | | | | | |
| 10 | Өвөрхангай | 6 | 7 | 3 | | | | | |
| 11 | Өмнөговь | 12 | 23 | | 8 | | | | |
| 12 | Төв | 8 | | 12 | 60 | | | 2 | |
| 13 | Увс | 7 | 8 | 14 | | | | | |
| 14 | Ховд | 16 | 38 | | | | | | |
| 15 | Хөвсгөл | | | 2 | | 3 | 2 | | |
| 16 | Хэнтий | 5 | | 8 | 40 | | | | 100 |
| | | 92 | 158 | 58 | 173 | 5 | 10 | 2 | 100 |

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ